# Л. Өлзийтөгс “Аквариум”


Хам сэдэв
Орчин
Дүр
Зохиомж
Дүрслэл
Сэдэв, асуудал, гол санаа
Туульсын зохиолын эдгээр бүрдэл хэсгүүд сүлжилдэж, уран зохиолыг уншигчийн сэтгэлд хүргэдэг.

# Зохиолын сэдэв, дэвшүүлсэн асуудал, гол санааг тодорхойлоорой.




Аквариум- Хот суурин газар
Загас – хоргонд хоригдож, эрх чөлөөгөө хасуулж буй хүн.

# Хам сэдэв гэж юу вэ?

**Зохиолын сэдэв, дүрийг тодруулж буй орон, цаг үе, нийгэм, соёлын нөлөөлөл, үзэл бодол зэрэг зохиолын хамгийн их мэдээлэлтэй хэсгийг хэлнэ.**

- Түүхийн хам сэдэв
- Нийгмийн хам сэдэв
- Соёлын хам сэдэв
- Шашны хам сэдэв
- Улс төр, эдийн засгийн хам сэдэв

Нийгмийн хам сэдэв \ бусдаас илүү хамаагүй, илүү орон зай хэрэгтэй байсан, тайвшрах юм байсан ч зовоох юм олон, нөхөр нь албан тушаалаас бууж, хүү нь үймүүлэхээ больж, охин юм хурааж цуглуулдаг болж, загаснаас 3 хүслээ гуйж ... Амьтад гунигладаг, ганцаарддаг, уйддагийг хэн ч ойлгохгүй нь харамсалтай, өдөр хоног өнгөрч, би гунигтаа, ганцаардалдаа, уйдалтандаа дасав.

# Орчин \ setting\ гэж юу вэ?

- Зохиолын үйл явдал болж байгаа орон газар, үйл явдал болж байгаа цаг хугацааг зохиолын орчин гэнэ. Зохиолын орчин нь дүрийн зан төрхийг дэмжих, сэдвийг дэмжих, гол санааг дэмжих зэргээр холбоо хамаарал үүсгэнэ.
- Орчинг тодорхойлохдоо:
- Орон, цагийг заасан үгийг түүнэ.
- Зохиолд дүрсдэгдсэн орон, цаг бүрд гол дүрүүд ямар үйлдэл хийснийг тодорхойлно.
- Энэ задлалаас зохиолын сэдэв, гол санаа, дүрийн зан төрхийн ялгараа харагдана.

# Үйл явдлын орчныг тодорхойлоорой.

## Аквариумд-гол дүрийн загас

Өөрөө аквуриум худалдаж авсан бас харамссан.
Арьсны өнгө хувирсан.
Уйлдаг
Сэтгэл нь зовоостой
Аавын охиндоо хэлсэн үгийг сонсоод үсрээд гарахыг шахсан.
Аквариумдаа дассан.
Охиндоо танигдахыг хичээсэн.
Охиныхоо гуйлтад зүрх нь эмтрэх шиг болсон.
Охиноо өрөвдсөн.
Гунигладаг, ганцаарддаг, уйддагийг нь бусад нь мэдрэхгүй байгаад харамссан.
Энэ бүхэнд дассан.

Халамжийн тогтолцоо, гэр бүлийн тэгш бус байдал

## Гэр бүлд –туслах дүр

Эмэгтэйг загас болсныг мэдээгүй
Архи уудаг болсон.
Ах дүү нар нь ойр ойрхон ирдэг болсон.
Усаа тохируулж чадахгүй мөртлөө охин загас авч өгөхийг шалдаг. Ээжийгээ загас болсны хойно бэх хийж алахаа шахсан.
Нөхөр нь завгүй даргыг ажлаасаа буусан.
Хүү уймүүлэхээ больсон.
Охин хурааж цуглуулах дуртай болсон.
Охин загаснаас хүслээ гуйсан.

Эмэгтэй хүн хэтэрхий ахуйд баригдаад, нийгмийн амьдралаас тасарч, гэр бүлдээ хэтэрхий их анхаарсан.

Гэр бүл бол нийгмийн орчин. Хэтэрхий халамж, хайр ивээлээс болоод амьдрах чадваргүй, гэр бүлийн үүргээ мэддэггүй, өөрийгөө илэрхийлэх чадваргүй ийм хүн болж байна.

Аквариум (гэр бүл) – Гэр бүл (нийгэм)

# Зохиолын нөхцөл байдал \situation\

- Зохиолд дүрслэгдэж байгаа орон, цагийн доторх хүрээлэн буй орчин дахь хүн,юмсын дүрслэлийг хэлнэ.
- Нөхцөл байдлыг тодорхойлохдоо:
- Тухайн орчинд \орон, цаг\ ямар, хүн, юмсыг дүрсэлснийг тогтоох
- Тухайн нөхцөл байдал нь дүрийн зан төрхийг харуулахад яаж нөлөөлж байгааг тайлбарлах

Нөхцөл байдал

## Эмэгтэй байхад

Охин загастай болохыг шалдаг
Нөхөр нь завгүй ажилладаг.
Хүү нь зөрүүдэлдэг.
Хэвлүүн, сахилгагүй
Ах дүү нь цөөн ирдэг.

Эмэгтэй загас болоод хувирчихсан.

## Эмэгтэй байхгүй болоход

Нөхөр нь үхэн хатан зүтгэсэ өндөрлөгөөсөө буучихсан.
Охин нь загасны усаа тохируулж чаддаггүй
Хүү нь нэг л биш болсон.
Ах дүү нар нь ойр ойрхон ирж 2 хүүхдийг нь асарч сувилдаг болсон.

Халамжийн тогтолцоо, гэр бүлийн тэгш бус байдал

# Зохиолын уур амьсгал \atmosphere\

- **Зохиолд дүрслэгдсэн дүрүүдийн хоорондын харилцаа, сэтгэгдэл, мэдрэмж, сэтгэл хөдлөлийг зохиолын үг хэлээр дамжуулан дүрсэлснийг хэлнэ.**

Уур амьсгалыг тодорхойлохдоо:

- Дүрийн тухайн хүн, юмсын талаарх сэтгэгдэл, мэдрэмж, сэтгэл хөдлөлийг дүрсэлсэн үг хэллэгийг ажиглах
- Зохиолын дүрүүдийн харилцан, яриа, бодлыг ажиглах
- Ямар орчин, нөхцөлд дүр хоорондын харилцаа яаж өөрчлөгдөж байгааг тэмдэглэх
- Эндээс уншигч та ямар өнгө аясыг мэдэрч, юуг ухаарч байгааг тайлбарлана.

Уур амьсгал

| Эмэгтэй | | Гэр бүлийн бусад гишүүд |
| --- | --- | --- |
| Загас болсон | → | Гэр бүлийнх нь мэдээгүй, |
| Алга болсон. | → | Нөхөр нь хамаг байдгаа зарцуулж, хайсан, уйлсан. |
| | → | Хүү түгжигдмэл, дүнсгэр болсон. |
| Таатай байсан. | → | Аав нь охиндоо анхаарал тавьдаг болсон. |
| Зүрх нь эмтэрсэн. | → | Охин 3 хүсэл гуйсан. |

Тэгш бус үүрэг. Хэт их үүрэгтэй нь үгүй болохоор нөгөөгийн мөн чанар харагддаг.